

АЙМГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААР ӨГӨХ САНАЛ

2018.11.29.

Булган

Булган аймаг дахь Төрийн аудитын газар МУ-ын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2.4 дэхь “Орон нутгийн төсвийн төсөлд болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар санал боловсруулж аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах;” гэсэн заалтыг үндэслэн Сангийн ямаар хянуулж УИХ-аар батлагдсан 2019 оны төсвийн төсөл, харьяа агентлаг, салбар байгууллагуудаас ирүүлсэн төсвийн төсөлд тусгах санал, баримтыг үндэслэн орон нутгийн төсвийн төсөлд хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар боловсруулсан саналаа аймгийн ИТХ-д хэлэлцүүлэхээр оруулж байна.

НЭГ. 2018 оны төсвийн төслийн орлого, зарлагын талаар:

2019 төсвийн онцлог нь

- Өмчийн ашиглалт хамгаалалт, бүртгэлийг сайжруулах зорилгоор 2019 оны төсвийн жилээс эхлэн сумын эмнэлэг болон боловсролын байгууллагад 2 нягтланг шилжүүлэн ажиллуулж, харин сумын Засаг даргын тамгын газрын бүтэц орон тоонд сумын санхүүгийн албыг хэвээр үлдээн 3 орон тоотойгоор ажиллуулахаар болсон, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сумын эрүүл мэндийн төв зэрэг 7 байгууллагын байр ашиглалтын зардал /гэрэл цахилгаан, халаалт, цэвэр бохир ус, байрны түрээс, урсгал засвар/-ыг орон нутаг хариуцдаг байхаар Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан,
- Соёл урлаг, спортын чиг үүргийг орон нутаг бие даан хэрэгжүүлэх болсон,
- Баяр наадам тэмдэглэх, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах гэх мэт урьдчилан төлөвлөх боломжтой зардлыг нөөц хөрөнгөөс санхүүжүүлдэг байсныг өөрчлөн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тооцож шаардагдах зардлын хэмжээг тооцсон,
- Сумын Ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх зорилгоор сум бүрт ахмадын хорооны үйл ажиллагааны зардал гэж тусгасан зэрэг онцлогтой байна.

1.Орон нутгийн 2018 оны суурь орлогыг

- ✓ СТСХ төсвийн суурь орлогыг 21.6 тэрбум төгрөгөөр тооцсоныг УИХ өөрчлөлгүй баталсан
- ✓ УИХ-ын баталсан дүнг аймгийн СТСХ 1.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 23.1 тэрбум төгрөгөөр төсвийн төслийг боловсруулжээ.

2018 оны суурь зарлагыг

- ✓ СТСХ төсвийн суурь зарлагыг 27.1 тэрбум төгрөгөөр тооцсоныг УИХ 23.0 тэрбум төгрөг болгон 4.1 тэрбум төгрөгөөр бууруулан баталсан
- ✓ УИХ-ын баталсан дүнг аймгийн СТСХ 2.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 25.9 тэрбум төгрөгөөр төсвийн төслийг боловсруулжээ.

Аймгийн 2018 оны нийт зарлагыг

- ✓ УИХ аймгийн нийт зарлагыг 56.7 тэрбум төгрөгөөр баталсныг СТСХ 3.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 59.7 тэрбум төгрөгөөр төсвийн төслийг боловсруулжээ.

ХОЁР.2018 оны төсвийн төсөлд өгөх санал:

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтын дагуу аймгийн Засаг даргаас аймгийн Төрийн аудитын газарт ирүүлсэн аймгийн 2018 оны төсвийн төслийг хүлээн авч СТСХ-т төсвийн төслийг боловсруулахад гаргаж ирүүлсэн тоо, баримт мэдээлэл, өмнөх оны төлөвлөлт, ХБГ, аймаг, сумын боловсруулсан төсвийн төсөл, УИХ-аар баталсан дүн зэргийг харьцуулсан тооцоолол, үндэслэл, хийсэн аудитаар цуглуулсан тоо, материалд судалгаа, дүн шинжилгээ хийж орон нутгийн төсвийн төсөлд төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаарх дүгнэлтийг танилцуулья.

2.1.Төсвийн үр ашгийг дээшлүүлэх талаар:

Аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн гүйцэтгэл, нийцлийн аудитуудаас гарч байгаа зөрчил, дутагдлыг үндэслэн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр дараахь саналуудыг оруулж байна.

Аймаг, орон нутгийн төсөв, санхүүтэй холбоотой:

1.Сумдын газрын төлбөрийн орлого 2013 оноос аймгийн төсөвт ордог тул сумын удирдлага, албан тушаалтнуудын орлого бүрдүүлэх хяналт, анхаарал суларсан, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 36 дугаар тогтоолоор газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хугацаа дуусаж, сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө хийх хүртэлх хугацаанд сумын ИТХ-д иргэний ахуйн хэрэгцээ, газар тариалан, өвөлжөө, хаваржааны газраас бусад газрыг олгохгүй байхаар тусгагдсан, байгалийн баялаг ашигласны төлбөрийн орлого дутуу төлөвлөгдөж хэрхэн биелүүлж байгаад тавих хяналт хангалтгүй, хог хаягдлын хураамж орлого байнга тасардаг, дээрх орлогуудыг хариуцаж хураах албан тушаалтан тодорхойгүй, тасарсан орлогын шалтгаан нөхцөлийг тогтоож, ажлын хариуцлага тооцдоггүй, Татварын тухай хуулийн 29.1.10 “албан татвар, төлбөр, хураамж, алданги, торгуулийг хуульд заасан хугацаанд хурааж төсөвт оруулах” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйд анхаарч орлогыг төлөвлөх, бүрэн биелүүлэхэд анхаарч ажиллах,

2.Тусгай хамгаалалттай газар нутгийн ойн цэвэрлэгээний ажил төлөвлөсөн хэмжээнд хийгдэггүйгээс сум, орон нутгийн татварын орлого тасарч байгаад анхаарах

3.Сумдын Засаг даргын нөөцийг журмын 3.1 дэх “Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна” гэж заасны дагуу зөвлөлийн хурлын шийдвэргүйгээр зарцулдаг, сумд баяр наадмын зардлыг Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолоор 5.0 сая төгрөгөөр тотоож өгсөн байтал 2017, 2018 оны наадмын зардалд дундажаар найман сум 5.0, дөрвөн сум, тосгон 6.0-9.0, нэг сум 15.0, хоёр сум 20.0 нийт 133.2 сая төгрөгийг ОНХС-гаас, нэмж Засаг даргын нөөцөөс зарцуулсан, хууль, журмаар тогтоосон хэмжээнээс 48.2 сая төгрөгөөр илүү зардал гаргасан байгаад анхаарч журмыг хатуу баримталж ажиллах

4.ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 519.8 сая төгрөгийн 160.0 сая төгрөгийн үлдэх өртөгтэй ашигладаггүй, эвдэрсэн, элэгдлээ бүрэн нөхсөн 11 барилга, байгууламжийг худалдан борлуулах арга хэмжээ авах,

5.Сумдын ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн бүртгэлд 12 нэр төрлийн 195 автомашин бүртгэлтэй байгаагаас ашиглахгүй байгаа, өртөгөө нөхөж элэгдэл нь дууссан 742.8 сая төгрөгийн өртөгтэй, 218.0 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 23 автомашин, тээврийн хэрэгсэл, мотоцикл байгаад анхаарч, ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд хий бүртгэлтэй Сэлэнгэ, Сайхан сумын 3 авто машин худалдагдсан, гэрээгээр ашиглаж байгаад хувь хүнд шилжсэн авто тээврийн хэрэгслийг акталж данс бүртгэлийг хасах,

6.Сумдын орон нутгийн хөгжлийн сангаас журам зөрчин олон нийтийн цагдаа ажиллуулах цалин, хувцас, цагдаагийн бэлэн бус торгуулийн машин худалдан авах, драйвер, компьютер, принтер, нийтийн хогийн цэгийн сахиулын цалин, хүндэтгэлийн гэр худалдан авах, байгаль орчины хяналтын пост ажилуулах, интернэт холболт шилэн кабель суурилуулалт зэрэгт зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.1 дэх “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр арга, хэмжээ” гэсэн заалтыг зөрчиж 10 төсөл арга хэмжээнд нийт 42.1 сая төгрөгийг зарцуулсанд дүгнэлт хийж хууль, журмаар хориглосон арга хэмжээнд зарцуулахгүй байх,

Орон нутгийн хөрөнгө оруулалт:

1.Дашинчилэн, Бүрэгхангай, Хангал, Орхон сумын ЗДТГ-ын суудлын автомашин шинэчлэх 200.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээ төсөвлөсөн нь Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” 30 дугаар тогтоолын 6.1 дэх “Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн зардлыг дараахь байдлаар хянаж суурь зарлагад тооцно:” 6.1.4 дэх “тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдаж авахаар бол өмнө нь ашиглаж байсан хөрөнгө нь зохих элэгдлийн нормд заасны дагуу өртгөө бүрэн нөхсөн эсхүл зохих журмын дагуу хэрэглээнээс актлагдсан бол орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэлээс хасагдсаныг нотолсон байх;” гэсэн заалтуудыг зөрчиж байгаа элэгдлээ бүрэн нөхөөгүй, ашиглалтын хугацаа дуусаагүй тул хасах,

2.Хөдөөгийн багийн Засаг дарга нарыг 69 ш мотоциклээр хангах 103.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын зардлаас Бүрэгхангай сум нь 2017 онд 4 багийн Засаг даргад хандиваар мотоцикл авч одоо ашиглаж байгаа тул 4 мотоциклийн үнэ 6.5 сая төгрөгийг хасах

3.Сэлэнгэ, Гурванбулаг сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийлгэхгүй бол аймаг нийт өртөгөөр гаргах боломжгүй тул нийт 300.0 сая төгрөгийг хасах

4.2019 оны төсвийн саналд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1073.5 сая төгрөгийн 22 ажил төсөвлөснөөс “Ахмадын өргөө” цогцолбор төв барих 1200.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий зураг, төсөв хийгдээгүй ажлыг төсвийн төсөлд тусгасан нь Төсвийн тухай хуулийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.”; Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” 30 дугаар тогтоолын 6.1 дэх “Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн зардлыг дараахь байдлаар хянаж суурь зарлагад тооцно:”, 6.1.2 дахь “шинээр барих барилгын зураг төсөв, техникийн бусад зөвшөөрөл,” гэсэн заалтуудыг зөрчсөн цаашид аймаг санхүүжүүлэх боломжгүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх ажил тул 2019 оны төсвийн төслөөс 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хасах

Байгаль хамгаалах сан:

1.ТЭЗҮ-гүй, тооцоо баримтгүй, Төсвийн тухай хуулийн 29.4-д заасан заалтыг зөрчсөн хасах төсөл арга хэмжээнүүд:

- Могод сумын Хульжийн рашааны ордын нөөцийг нарийвчлан тогтоох ажил тооцоо судалгаа, ТЭЗҮ-гүй 200.0,
- Ногоон хөгжлийн бодлогын дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ төсөвт өртөгийн тооцоололгүй 150.0,
- Гурванбулаг сумын доройтсон бэлчээрийг зайнаас танадан судлах, нөхөн сэргээх, туршилт судалгааны бааз барих ажил ТЭЗҮ-гүй 300.0,
- Хог хаягдлын улсын тоо бүртгэл, норм норматив тогтоох ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, тооллого хийх ажил тооцоо судалгаа, байхгүй 7.5,
- Баяннуурыг сэргээх зураг, төсөл боловсруулах 32.0,
- Хануй, Хөвсгөл нуур-Эгийн гол, Сэлэнгэ, Орхоны Чулуут, Туулын сав газруудын хамгаалалтын бүс тогтоох 50.0

2.Төлөвлөсөн төсөвт өртөгийг бууруулах боломжтой төсөл арга хэмжээнүүд:

- Үлийн цагаан огтоотой тэмцэх ажлын 100.0 сая төгрөгийг хасах,
- Ой бүхий сумдад ойн хортны судалгааны ажил /500000 га/ өмнөх он 250000 га-д хийсэн гүйцэтгэл 24.8 сая гарсныг үндэслэн 25.0 сая төгрөгөөр бууруулах,
- Усан хангамж, ариутгах татуурга, төвлөрсөн шугам, сүлжээний ажлын зураг, төсөв боловсруулах /Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг, Рашаант/ ажлын төсөвт өртөгийг 841.3 сая төгрөгийг 250. сая төгрөг болгож 454.6 сая төгрөгөөр бууруулах,.

3.Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлангах журам”-д заагдаагүй, журманд нийцэхгүй тул хасах төсөл хөтөлбөрүүд:

- Бүх төрлийн зургийг хэвлэх plottor хэвлэгч худалдан авах /ГХБХБГ/ 17.5,
- ТЭЗҮ-гүй хийгдсэн аялал жуучлалын цогцолборын үргэлжлэл 250.0,

- Аялал жуулчлалын цогцолборын II шатны дуусгалын зураг төслийн 50.0 сая төгрөгийн ажлууд нь холбогдох журамтай нийцэхгүй тул төслөөс хасах

Орон нутгийн хөгжлийн сан:

- Хишиг-Өндөр сумын эмнэлгийн шинэ, хуучин барилгыг хүзүүвчээр холбох ажил нь зураг төсөвгүй тул 41.0,
- Рашаант сумын багийн хөгжлийн төв барих ажил зураг төсөвгүй тул 15.0,
- Аймгийн Нөөцийн газрын саравч барих, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын 50.0 сая төгрөгнөөс ОНХС-ийн зарцуулах журмын 7.2.5-ын а дахь "Өвс тэжээлийн нөөцийн агуулах барих, засварлах" гэсэн заалтыг зөрчиж байгаа тул 34.7,
- Аймгийн баяр наадмыг тэмдэглэхэд 40.0 сая төгрөг төсөвлөснийг Засгийн газрын 2010 оны 271 дүгэр тогтоолыг үндэслэн 30.0,
- Техник технологи, инноваци нутагшуулах, үйлдвэрлэлийн бүсийн үйл ажиллагааны ТЭЗҮ боловсруулах ажлын гэрээгээр 95.2 сая төгрөг олгохоос энэ онд үлдэгдэл 49.0 сая төгрөг тусгасны илүү тооцсон 1.4,
- Тэшиг сумын Жаргалант багийн 120 хүүхдийн хүчин чадалтай хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын ТЭЗҮ, баримт бичиг байхгүй тул 220.0 сая төгрөгийг тус тус хасах

2.2. Орлого нэмэгдүүлэх талаар

Орон нутгийн орлого:

1. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2011 оны 111 тоот тогтоолоор батлагдсан "Орон нутгийн авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам"-д заасан зам ашигласны төлбөрийн хураамжийг 2014 оноос эхлэн авч 2015 онд 40.1, 2016 онд 45.0, 2018 онд 54.2 сая төгрөгийг авто замын санд төвлөрүүлсэн, 2018 онд аймгийн Татварын хэлтэс, Авто тээврийн төвийн баазад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо 12000, 2018 онд нийт хяналтын үзлэгт 9276 тээврийн хэрэгсэл хамрагдсан үүнээс 538 мотоцикль, чиргүүлийг хасаад 8738 авто машин үзлэг оношлогоонд хамрагдсан зэргийг үндэслэн зөвхөн орон нутгийн харьяалалтай гэж үзэж 8738 машинаар тооцоход авто зам, замын байгууламж ашигласны төлбөрт 87.3 сая төгрөг үүнээс төсвийн төсөлд 44.8 сая төгрөгийг хасаад 35.2 сая төгрөгөөр,

2. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн сүүлийн 3 жилийн дунджаар авч үзэхэд 69.0 мянган төгрөгийн орлого орно гэж үзвэл 2019 төсвийн төсөлд өгсөн саналыг 17.9 сая төгрөгөөр,

3. Татварын хэлтсээс ирүүлсэн 2018 оны 1/351 тоотын хавсралт судалгаагаар нийт 426.2 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөгдөхөөр бүртгэгдсэн үндэслэн үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогыг 1.8 сая төгрөгөөр,

4. Замын цагдаагийн бэлэн бус торгуулиар 2017 онд 539.8, 2018 онд 521.2 сая төгрөгийн торгууль бичигдсэн, гүйцэтгэлээр аймаг болон сумын хүү, торгуулийн дансанд 2017 онд 274.8 сая, 2018 онд 329.8 сая төгрөг төвлөрчээ. Гүйцэтгэлийг тооцохдоо сумдын хүү торгуулийн дансанд орсон нийт дүнгээр авсан бөгөөд үүнээс цагдаагийн торгуулийг цэвэр дүнгээр тооцвол үлдэгдэл өсөх боломжтой, 2017, 2018 оны торгуулийн үлдэгдэл нийт 456.3 сая төгрөгөөр хүү торгуулийн орлогыг тус тус нэмэгдүүлэх

Аймгийн ИТХ-д Төрийн аудитын газрын тооцоолсноор төсвийн үр ашгийг дээшлүүлэх 3253.5, орон нутгийн төсвийн орлогыг Санхүү төрийн сангийн хэлтсийн тооцоолсон төсвийн төсөлд 511.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна гэж үзэн боловсруулсан саналыг хурлын төлөөлөгчид та бүхэнд танилцуулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР